



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.21 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт хийгдэх тохижилтын ажлын судалгааг хийх, тохижилтын ажлын дүнд бий болсон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, эзэмшил ашиглалтын байдалд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хот тохижилтын бусад зардлаас санхүүжиж буй тохижилтын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор байгуулсугай.

2. Энэхүү ажилд шаардагдах зардлыг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажиллахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА *[Signature]* Т.ТАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 01 сарын 21 өдрийн  
тушаалын 1944/р хавсралт



### ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	Д.Лувсанчимэд	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хэлтсийн мэргэжилтэн
	Б.Халиун	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тооцооны нягтлан бодогч
	Т.Мөнхнасан	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3-р хороо, 24-39 тоотод оршин суугч иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 01 сарын 21 өдрийн  
А/З тушаалын 2 дугаар хавсралт



ХОТ ТОХИЖИЛТЫН БУСАД АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ЗАРДЛААС САНХҮҮЖИХ ТОХИЖИЛТЫН  
АЖЛЫН СУДАЛГАА ХИЙХ,  
ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ТӨСӨВ

№	Төсөл арга хэмжээний нэр	2019 онд санхүүжих дүн /сая төгрөг/
1	Тохижилтын ажлын судалгаа хийх, хяналт тавих	50.0
	Дүн	50.0